

МОНГОЛ АЛТАЙД ИЛЭРСЭН ПАЛЕОЛИТЫН ҮЕИЙН ХАДНЫ ЗУРГИЙН ШИНЭ ДУРСГАЛ: БАГА ОЙГОР-VI (Танилцуулга өгүүлэл)

Ц. Төрбат^{1,*}, Н. Батболд², Б. Өмирбек³

Товч агуулга: Дэлхийн өв - Монгол Алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын бүсэд багтах Бага Ойгор-VI дурсгалт газарт чулуун зэвсгийн үед хамаарах хадны зургийн томоохон бөөгнөрөлийг анх 2004 онд Ц.Төрбат илрүүлсэн бөгөөд 2019 онд Ц.Төрбат, Н.Батболд, Б.Өмирбек нар баримтжуулж судалсан байна. Уг цогцолбор нь дээд палеолитын үед хамаарах адуу, янгир, аргаль, буга, үхэр, могой зэрэг амьтдын дүртэй 41 зураг, хүрлийн үед хамаарах 16 зураг, нийт 57 зургаас бүрдэнэ. Уг дурсгалын хадгалалтын байдал ижил төстэй дурсгалуудаас хавьгүй сайн бөгөөд үзэгдэх байдал нь тод томруун юм. Үүнтэй ижилсэх палеолитын үеийн сийлмэл зургийн нээлттэй дурсгалууд дэлхийд харьцангуй цөөн байдаг бөгөөд газар зүйн хувьд хамгийн ойрын дурсгал нь Өмнөд Кавказын Гобустаны дурсгал бөгөөд хамгийн том бөөгнөрөл нь Иберийн хойгт байна. Алдарт Хойд Цэнхэрийн агуйн зосон зургийн зэрэгцээ палеолитын үеийн олон тооны сийлмэл зургийн дурсгалууд нээгдээд байгаа тул Монгол Алтайн бүс нутгийг дурсгалуудын тоо, тархалтын хэмжээг харгалзан үзэж “өвөг урлагийн голомт нутаг” гэж тодорхойлж болохоор ач холбогдолтой газар болоод байна.

Түлхүүр үг: дээд палеолит, хадны зургийн нээлттэй дурсгал, сийлмэл ба хонхойлгосон зураг, Монгол, Алтай

Удиртгал

Монгол Алтайн хадны зураг ЮНЕСКО-ийн Дэлхийн өвийн жагсаалтад бүртгэгдэж дэлхийд данстай болсон бөгөөд Монголын археологийн бэлгэдэл болсон гайхамшигт дурсгалууд билээ. Хамгийн сүүлийн үеийн нэгэн бүртгэл судалгаагаар Монгол Алтайн бүс нутгийн Баян-Өлгий аймгийн нутагт хадны зургийн 61 дурсгалт газар бүртгэгдсэн байна. Эдгээрийн дотор хадны зургийн урлагийн хамгийн эртний давхарга болох чулуун зэвсгийн үеийн зургууд ч цөөнгүй бий. Дэлхий дээр харьцангуй ховор байдаг чулуун зэвсгийн үеийн сийлбэр зургуудын томоохон төвлөрөл Монгол Алтайд байгаа нь илэрхий зүйл болоод байна.

Эдгээр дурсгалын дотор Ховд аймгийн Манхан сумын Хойд Цэнхэрийн агуй, Увс аймгийн Сагил сумын Хад үзүүр, Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Цагаан Салаа-Бага Ойгор, Цэнгэл сумын Арал толгой зэрэг газрыг дурдаж болно. Плейстоцений сүүл үеэс голоцений эхэн үед мөстлөгийн эрч суларч уулсын хөндийнүүд мөсөн хучлагаас чөлөөлөгдөх

хэрээр анчид улам бүр нам дор хөндийгөөс дээш өгсөж энэ бүс нутгийг эзэмшиж эхэлсэн бололтой. Энэ үйл явц хадны зурагт тусгагдан үлдсэнийг дээрх дурсгалуудаас харж болно (Төрбат нар 2009: 28).

Гэхдээ судлаачдын дунд дээр дурдсан дурсгалуудын он цагийн асуудал хурц маргаантай байдаг бөгөөд зарим тохиолдолд нэг судалгааны багийн гишүүдийн дунд хүртэл санал зөрөөнтэй байх нь тохиолддог. Жишээлбэл, Монгол-Орос-Америкийн “Алтай” төслийн багийн Д.Цэвээндорж, Э.Жейкобсон нар нь Цагаан Салаа-Бага Ойгорын зарим зураг болон Арал толгойн дурсгалын ихэнх зургийн он цагийг плейстоцений үеэр буюу палеолитын дээд үеэр тогтоож байгаа бол В.Д.Кубарев эдгээр зургуудыг хавьгүй хожуу үе буюу хожуу неолит, түрүү хүрлийн үеэр тогтоодог (Төрбат нар 2009: 29-30). Үүнтэй ижил төстэй нөхцөл байдал Орос Алтайн Калгутинский рудник дурсгалын хувьд ч давтагдсан (Кубарев 1997; Молодин, Черемисин 1999; Молодин и др. 2021).

Хэдийгээр Монгол Алтайн болон хил залгаа бүс нутгийн чулуун зэвсгийн үеийн хадны зургийн дурсгалуудын үнэмлэхүй он цагийг тогтоосон зүйл одоогоор хараахан үгүй байгаа боловч Европын болон бусад нутгийн он цаг нь баттай тогтоогдсон дурсгалуудтай дүрслэл ба дүрслэх аргын хувьд харьцуулан судалж тогтоосон харьцангуй он цагийн баримжаа палеолитын сүүл үе рүү чиглэж байгааг бид дэмжиж байна. Энэ чиглэлд Оросын нэрт судлаач

¹ МУИС, Шинжлэх Ухааны Сургууль, Археологийн судалгааны төв, Антропологи, Археологийн тэнхим

* Холбоо барих зохиогч: turbat.ts@num.edu.mn
<https://orcid.org/0000-0001-6606-8516>

² ШУА-ийн Археологийн хүрээлэн

³ Дэлхий өв Монгол Алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргаа

В.И.Молодин, Д.Черемисин нарын Калгутинский рудник дурсгалын он цагийн талаарх олон жилийн тууштай судалгаа олон асуудлын шийдлийг гаргаж байгааг тэмдэглэх нь зүйтэй (Молодин, Черемисин 1999, 2007; Дэвлет, Дэвлет 2001; Молодин и др. 2019, 2021; Молодин 2022). Түүнчлэн Монгол Алтайн хадны зургийн дотор одоогоос 4600-3800 жилийн өмнө хамаарах түрүү хүрлийн үеийн буюу Хэмцэгийн соёлд холбогдох давхаргыг нээн тогтоосон явдал (Төрбат 2019) түүнээс илүү эртний зургуудын харьцангуй он цагийг тогтооход дам боловч баримжаа болж байгааг дурдая.

2004 онд Цагаан Салаа-Бага Ойгорын хадны зургийн цогцолборын бүсэд нэгэн чухал хадны зургийн дурсгалыг Ц.Төрбат анх илрүүлж, 2019 онд зохиогчид хамтдаа дахин илрүүлж олсон юм. Энэ бол Цагаан Салаа-Бага Ойгорын хадны зургийн цогцолборт илрээд байгаа плейстоцений цаг үед хамаарч болох хамгийн том зургийн бөөгнөрөл юм. Энд дээд палеолитын үед хамаарч болох 41 зураг нэгэн чуулбар болон байрлаж байна. Энэ жижиг өгүүлэлд бид уг дурсгалын товч танилцуулга, нээж илрүүлсэн түүх, хадгалалт хамгаалалтын асуудал болон дэлхийн палеолитын сийлбэр зургийн нээлттэй дурсгалууд дотор эзлэх байр суурийг товч хөндөн өгүүлэв. Энэ бол уг чухал дурсгалыг судлах ажлын дөнгөж эхлэл бөгөөд цаашид илүү дэлгэрүүлэн судлах болно.

Бага Ойгорын дурсгалт газар

Бага Ойгорын чулуун зэвсгийн хадны зургийг 2004 онд Ц.Төрбат ШУА-ийн Баян-Өлгий аймаг дахь Нийгэм, эдийн засгийн судалгааны төвийн эрхлэгч, доктор К.Бихумарын удирдсан шинжилгээний ангид тус төвийн ажилтан доктор Г.Золбаяр ба Х.Едилхан нартай хамт Цагаан Салаа-Бага Ойгор, Цагаан голын археологийн дурсгалуудыг бүртгэн баримтжуулах

чиглэлээр оролцон ажиллах явцдаа анх олж үзжээ. Хэдийгээр ховор чухал хадны зургийн дурсгал үзсэнээ мэдэж байсан боловч энэ аялал нь түүний анх удаа Монгол Алтайд очсон судалгааны ажил байсан төдийгүй түүнээс хойш олон жилийн турш ихэвчлэн хүрэл ба түрүү төмрийн үеийн оршуулгын дурсгалын чиглэлээр ажиллаж хадны зургийн чиглэлээр сонирхон судлаагүй тул уг дурсгалын байрлалыг ч эргэн санахгүй болсон байна. Гэвч үүнээс хойш тухайн бүс нутагт хадны зургийн чиглэлээр ажиллаж буй судлаачдад өөрийн авсан гэрэл зургуудыг үзүүлж, үзэж судалсан эсэхийг олон жил асууж байсан боловч мэдэх хүнгүй 2019 онд хүрэмэн юм. Ингээд 2019 онд Германы Бонны их сургуулийн Өвөг ба түрүү түүхийн археологийн тэнхимийн грант төслийн хүрээнд Монгол Алтайн Хэмцэгийн соёлын хадны зургийн судалгааны бичил төслийг доктор Н.Батболд, доктор Б.Өмирбек нарын хамтаар хэрэгжүүлж Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Цагаан Салаа-Бага Ойгор, Цэнгэл сумын Шивээт хайрхан, Буянт сумын Хойд Хөлцөөтийн голын хадны зургийн цогцолборуудад ажиллаж явах зуур 2004 оноос хойш дахин үзэж чадаагүй дурсгалт газраа 15 жилийн дараа дахин илрүүлсэн юм. Энэ явдалд Дэлхийн өв-Монгол Алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргааны дарга, доктор Б.Өмирбек гол үүрэг гүйцэтгэсэн юм. Тэрээр энэхүү дурсгалын зарим зураг дүрслэлийг 2021 онд хэвлэгдсэн нэгэн номондоо анх нийтэлсэн байдаг (Өмирбек нар 2021: 34).

Уг дурсгал нь Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутагт Бага Ойгорын голын урд эрэгт Хөх эргийн хилийн застав орох том шороон замын яг дэргэд байрлана (Дурсгалт газрын байрлалыг Зураг 1-ээс үзнэ үү). Хүний нүдэнд илэрхий тод харагдах улаан зам дээр байгаа энэ дурсгал наад зах нь 2004 онд Ц.Төрбатыг анх илрүүлснээс хойш 15 жил, археологийн идэвхитэй судалгаа хийгдэж эхэлснээс



Зураг 1. Бага Ойгорын хадны зургийн дурсгалт газрын байршил

хойш 25 жил өнгөрөхөд бусад судлаачдын нүдэнд өртөөгүй нь чухамдаа биднийг судлахыг хүлээсээр ирсэн мэт.

Манай судалгааны багийнхан дахин илрүүлсэн дороо энд буудаллаж хадны зургийн гэрэл зургийн баримтжуулалт ба полиэтилен цаасан дээрх хэв хуулгыг авах ажлыг хийж гүйцэтгэсэн юм (Зураг 3). Монголд төдийгүй дэлхийд ховорхон байдаг нэн эрт үеийн хадны зургийн дурсгалыг илрүүлэн олно гэдэг, тэр дундаа дээр дурдсан бяцхан адал явдлыг туулж эргэж олно гэдэг сэтгэл хөдөлгөсөн хэрэг мөн билээ. Ийм ховор сайхан бэлгийг хүртэх нь Өндөр Алтайдаа олон жил залбиран явж, эртний соёлыг нь эзний ёсоор хайрлан судалж ирсэн бидний хувьд бүр ч эрхэм сайхан хэрэг байлаа.

Бага Ойгор-VI талбай буюу Хөх эргийн хадны зургийн дурсгалт газар 12,8 x 12,2 м хэмжээтэй нийт 114 м² талбайг эзэлсэн нэг бүлэг хадан дээр байна. Энд 20 зурагт хавтан байх бөгөөд нийт 57 зураг бий (Зураг 2). Түүний дотор чулуун зэвсгийн үед холбогдох 41 зураг байгаа бол хожуу үед, түүний дотор хүрлийн

үеийн 16 зураг дүрслэл байна. Эдгээр зургийн ихэнх нь газрын гадаргатай адил түвшинд байх тэгш хавтгай хаднууд дээр дүрслэгджээ (Зураг 3). Уг дурсгалт газрын эргэн тойронд нь өөр хадны зургийн бөөгнөрөл байхгүй, харьцангуй тусгаарлагдмал цогцолбор юм. Дашрамд дурдахад Цагаан Салаа-Бага Ойгорын хадны зургууд нь өргөргийн дагуу урсаж буй голынхоо хойд биед голчлон тархсан бөгөөд голын урд биед илт сийрэг тархацтай байдаг.

Бага Ойгор-VI дурсгалын хадны зургийн цогцолборын чулуун зэвсгийн үеийн нийт 42 зураг дүрслэлүүд дотор 10 буга (үүний нэг нь эвэргүй согоо), 7 адуу, 6 янгир, 6 аргаль (үүний нэг нь дутуу зурагдсан), 2 үхэр, 2 могой, 1 геометр дүрслэл болон 8 дутуу зурагдсан ямар нэгэн амьтан байна (Диаграм 1). Харин илэрхий хожуу үеийн 16 дүрслэлийн дотор 4 ширхэг хос морь хөллөсөн ганц тэнхлэгт тэрэг, 2 адуу, 3 янгир, 3 чоно, 1 буга, 3 ямар нэг амьтан зэрэг дүрслэл байна. Эдгээр зураг дүрслэлүүд хүрлийн үед холбогдох бололтой.


Хүснэгт 1. Бага Ойгор-VI хадны зургийн дурсгалын зураг дүрслэлүүд

Зурагт хавтан	Дүрслэлүүд
1	1 янгир, 3 аргаль, 1 дутуу зурсан аргаль
2	3 янгир (хожуу үеийн)
3	1 буга, 1 янгир
4	1 янгир
5	2 буга, 1 дутуу амьтан
6	2 буга, 2 янгир, 1 чоно (хожуу үеийн)
7	1 адуу, 1 буга, 1 согоо, 2 дутуу зурсан амьтан, 1 амьтан (хожуу үеийн)
8	1 аргаль, 3 буга, 1 дутуу зурсан амьтан
9	1 могой
10	1 могой
11	1 янгир, 2 дутуу зурсан амьтан
12	1 аргаль, 1 адуу, 1 дутуу зурсан амьтны толгой
13	1 адуу
14	1 үхэр
15	1 үхэр, 2 адуу, 1 дутуу зурсан амьтан, хожуу үеийн 1 буга, 2 чоно
16	1 адуу
17	1 адуу
18	Хожуу үеийн хос морь хөллөсөн 1 тэрэг, 2 адуу ба 2 амьтан
19	Хожуу үеийн хос морь хөллөсөн 2 тэрэг, үүний нэг нь жолоо барьсан хүнтэй
20	Хожуу үеийн хос морь хөллөсөн, жолоо барьсан хүнтэй тэрэг


Хэлэлцүүлэг

Одоогоор Монгол Алтайд баттай мэдэгдэж байгаа чулуун зэвсгийн үеийн хадны сийлбэр зургийн дурсгалууд дотор Баян-Өлгий аймгийн Арал толгой ба Цагаан Салаа-Бага Ойгорын дурсгалууд, Ховд

аймгийн Ишгэн толгой, Чандмань Хар үзүүр, Хад үзүүр зэрэг дурсгалууд зураг дүрслэлийн тоо хэмжээ, ба тархалтын цар хүрээгээр ялгаатай боловч ерөнхийдөө төстэй арга техникээр үйлдсэн бөгөөд хадны зургийн нэг уламжлалын хүрээнд багтах бололтой. Үүний дээр хил залгаа Орос Алтайн Калгутинский рудник



Зураг 2. Бага Ойгорын Хөх эргийн хадны зургийн цогцолборын зурагт хавтангуудын байршил (гар зургуудыг Н.Батболд, схемийг Б.Батдалай)



Диаграм 1. Чулуун зэвсгийн үеийн дүрслэлүүдийн тоо ба хувь хэмжээ



Зураг 3. 2019 онд Бага Ойгорын хадны зургийн дурсгалт газарт полиэтилен хальсанд хуулга хийж байгаа нь.
Зурагт зүүн гар талаас Г.Ихбаяр, Б.Өмирбек, Н.Батболд (гэрэл зургийг Ц.Төрбат © 2019)

дурсгалыг нэмэн дурдах хэрэгтэй. Мөн Зүүн ба Өмнөд Сибирийн хэд хэдэн хадны зургийн дурсгалуудад палеолитын үеийн зураг дүрслэл байна гэж Оросын эрдэмтэд үздэг болохыг нэмэн дурдая (Молодин 2009: 20). Энэ дурсгалын зургуудыг мөн л Монгол Алтайн чулуун зэвсгийн хадны зургийн арга барилаар бүтээгдсэн байдаг. Түүнчлэн дээд палеолитын цаг үед хамаарч болох агуйн зурмал зургийн агуу дурсгал Монгол Алтайн нурууны төв хэсэгт Хойд Цэнхэрийн агуйд байдаг билээ (Окладников 1972).

Баруун Европын баруун захад бөөгнөрсөн Франк-Кантабрийн хадны зургийн муж хэмээн нэрлэдэг агуйн зурмал зургийн дурсгалуудаас Монгол Алтайн сийлмэл зургууд хүртэл чулуун зэвсгийн зургууд, түүний дотор ялангуяа палеолитын зургийн дурсгал олон биш. Оросын Уралын нуруунд байгаа Каповын ба Игнатьевын агуйн зургууд юуны түрүүнд ихэд алдаршсан бөгөөд судлаачдын тодорхойлсноор “урлагийн голомт” (Формозов 1983: 8) хэмээн үнэлэгддэг. Тэгвэл Төв Азид мөн өөрийн гэсэн “урлагийн голомт” байсан тухай онолыг алдарт археологич А.П.Окладников гаргасан бөгөөд түүнийг нь академич В.И.Молодин нарийн шинжилж, гаргасан үндэслэл бүрийг нь нэгбүрчлэн авч үзээд дэмжсэн байдаг (Молодин 2009). Хэдийгээр сүүлийн жилүүдэд палеолитын үеийн зурмал болон сийлмэл зургууд зөвхөн Франк-Кантабрийн мужаар хязгаарлагдахгүй Европ тивийн бусад газар орноос ч илэрч олдсоор байгаа боловч томоохон бүлэг, голомт гэж нэрлэж

болохоор хэмжээнд хүрэх зүйл Иберийн хойгоос гадна үгүй байна. Харин Монгол Алтайн бүс нутаг дурсгалуудын тоо, тархалтын хэмжээгээр авч үзвэл үнэхээр “өвөг урлагийн голомт нутаг” гэж тодорхойлж болохоор ач холбогдолтой газар болоод байна.

Палеолитын хадны зураг дотор агуйн зургууд, тэр дотроо зурмал зургууд давамгайлдаг. Тухайлбал дэлхий дээр палеолитын үеийн 400 гаруй агуйн зураг одоогоор мэдэгдэж байгаа бол нээлттэй хэлбэрийн палеолитын зургууд хэдэн арваас хэтрэхгүй байна. Хэдийгээр зарим агуйд сийлмэл зургууд тохиолддог боловч ихэнх сийлмэл дүрсүүд агуйгаас гадна “задгай тэнгэрийн доор” байдаг. Орчин үеийн археологт ийм хэлбэрийн дурсгалуудыг нэрлэх оновчтой ганц үгнээс бүрдсэн нэр томьёо бий болоогүй байна. Судлаачид “агуйн бус урлагийн дурсгал”, “задгай тэнгэрийн доорх урлагийн дурсгал” гэх мэтийн нэр томьёо хэрэглэсэн үзэгддэг (Бан 2009). Агуйн зургуудтай харьцуулахад ийм хэлбэрийн зургууд харьцангуй сүүлд олноороо илэрч, судалгааны хүрээнд он цаг нь хүлээн зөвшөөрөгдөх үйл явц ч харьцангуй саяхан болж өнгөрч байна. Үүнтэй холбогдуулан дурдахад палеолитын үеийн хадны зургийн дийлэнх нь агуйд бус харин нээлттэй орчинд байх хадан дээр зурагдаж байсан бололтой гэсэн санааг хадны зураг судлалын тэргүүлэх судлаачдын нэг Поль Бан гаргасан байдаг (Бан 2009: 6). Гэхдээ он цагийн уртад хамгаалалт сайтай агуйд хадгалагдан үлдээд задгай хадан дээрх зургууд нь улирч муудсаар хадгалагдан үлдсэн нь цөөн

байгаа бололтой. Ийм нээлттэй хадан дээрх зургуудын дийлэнх нь элдэв төрлийн будгаар зурагдсан харин зөвхөн цөөн хэд нь л сийлбэрлэх аргаар бүтээгдсэн байсан болов уу. Сийлбэрлэн бүтээсэн зургуудаа ч өнгийн будгаар будаж байсныг нөмөр сайтай хадан гадарга дээрээс зарим онцгой тохиолдолд илрүүлсээр байна.

Дэлхийн хадны зургийн судалгаанд палеолитын үеийн агуйн бус хадны сийлбэр зургуудыг илрүүлэн олж, мэргэжилтнүүд он цагийг нь хүлээн зөвшөөрсөн үйл явдлыг өндрөөр үнэлдэг бөгөөд хадны зураг судлаач Поль Баны тэмдэглэснээр бол ХХ зууны эхэн үед агуйн зурмал зургийг нээсэнтэй тэнцэхүйц хамгийн чухал үйл явдал болсон байна (Бан 2009: 7). Ийм төрлийн палеолитын зургууд байж болно гэдгийг хүлээн зөвшөөрөх судалгааны хүрээнд амаргүй замыг туулсан бөгөөд анхны томхон зургууд 1970-аад онд нээгдсэнээс хойш бүтэн арван жил өнгөрч байж мэргэжлийн судлаачдын анхаарлыг татаж байжээ.

Одоогийн байдлаар нээлттэй хадан зээрх сийлбэр зургуудын хамгийн том бөөгнөрөл Иберийн хойг буюу Испани, Португал улсын нутагт байна. Ялангуяа Португалийн палеолитын 70 гаруй хадны зургийн дурсгал дотор ганц хоёрыг эс тооцвол бүхэлдээ нээлттэй дурсгалууд байдаг ажээ (Santos & al. 2015). Тэдгээрийн дотроос хамгийн том бөгөөд олны анхаарлыг онцгой татсан дурсгал бол Коа голын хөндийн нээлттэй зургууд юм. Энд 17 км урт үргэлжилсэн талбайд 26 цогцолборт 234 хавтан дээр палеолитын сийлбэр зургууд байдаг ажээ (Zilhao et al. 1997; Bicho et al. 2007: 124). Эдгээр зургийн он цагийг хамгийн эртдээ граветтийн үеэс мадлений үе хүртэл буюу одоогоос 33,000-12,000 жилийн тэртээ хэмээн тогтоодог бөгөөд хонхойлгон сийлсэн зургууд нь илүү эртнийх, харин зураасан зургууд нь илүү хожуу үеийнх гэж үздэг (Bicho et al. 2007: 128-129). Испанид ч мөн Доминго Гарсиа зэрэг алдартай нээлттэй хэлбэрийн палеолитын зургууд цөөнгүй бий бөгөөд бүртгэн баримтжуулах ба судалгааны ажлууд ид үргэлжилж байна (Bahn 1995; Vázquez Marcos & Reis 2019). Тэдгээрийн дотроос Сиега Вердегийн хадны сийлбэр зургийн дурсгалыг 2010 онд Дэлхийн өвийн жагсаалтад оруулжээ (de Balbín Behrmann 2014).

Ийнхүү палеолитын үеийн агуйн бус сийлбэр зургууд голчлон Иберийн хойгт тархсан боловч бусад улсуудын нутагт цөөн тоотойгоор сүүлийн үед илрэх болсон байна. Тухайлбал, Хойд Английн Кресвелл Крег хавцлын Чёрч Хоул агуйн амьтдын сийлбэр зураг (Pike et al. 2005) Европын хамгийн хойд талын палеолитын зураг гэгддэг бол Германы баруун захын Рейнланд-Пфальц мужийн Гондерхаузен тосгоны Хунсрюк уулын чулуун хавтан дээрх зураг (Welker 2016) Европын хамгийн хойд талын агуйн биш хадны зураг гэгдэж байна. Тэгвэл хамгийн зүүн захын нээлттэй

сийлмэл зургууд Аппенины хойгт байгаа бөгөөд алдартай олон үеийн зураг бүхий Валькамоникагийн цогцолборт буй зарим зургийг палеолитын үеийнх гэж тодорхойлсон төдийгүй ерөнхийдөө Италид нэлээд олон хадны зургийн дурсгал энэ цаг үед холбогдохыг тогтоогоод байна (Sigari 2022). Харин Европоос гаднах палеолитын сийлбэр зургийн маш ховор дурсгалын дотор Египтийн Курта хэмээх Нил мөрний хөндийд байх дурсгалаас илрээд байгаагийн он цагийг OSL аргаар он цагийг нь одоогоос 15,000 жилийн өмнө хэмээн тогтоосон байдаг (Huyge et al. 2011). Эцэст нь, одоогоор мэдэгдээд байгаа палеолитын нээлттэй орчинд буй хадны зургийн дурсгалуудын дотроос (Монголоос гадна) хамгийн зүүн захад байгаа нь Азербайжаны Гобустаны дурсгал юм. Хэдийгээр уг аварга том дурсгал олон үеийн зургуудыг агуулах боловч хамгийн эртний давхарга нь 20,000 орчим жилийн тэртээ холбогдоно хэмээн судлаачид тогтоожээ (Sigari 2013). Үүнээс харахад нээлттэй дурсгал дахь палеолитын хадны сийлбэр зургууд дан ганц Иберийн хойгоор хязгаарлагдахгүй харьцангуй өргөн тархалттай болсон мэт харагдавч үнэндээ ийм төрлийн зураг маш цөөн байдаг бөгөөд, түүнийхээ хэрээр маш үнэ цэнтэй соёлын өв ба судалгааны хэрэглэгдэхүүн болдог юм. Иберийн хойгийн Коа голын, Сиега Верде ба Кавказын нурууны Гобустаны дурсгалууд ЮНЕСКО-ийн Дэлхийн өвийн жагсаалтад байдаг нь үүний нэг нотолгоо болно.

Эдгээрээс гадна манай сэдэвтэй хамааралтай нэгэн сонирхолтой дурсгал байдаг нь Өмнөд Украины тал нутагт байх Камяна Могила цогцолборын агуйнуудад байх сийлмэл зургууд юм. Хэдийгээр олон судлаач уг дурсгалын он цагийг палеолитын үед холбогдуулж үздэг боловч сүүлийн үед эргэлзээ төрүүлэхүйц үндэслэл бүхий судалгаанууд гарч байгаа (Radchenko & Kiosak 2022) тул палеолитын сийлмэл зургуудын тухай хэлэлцүүлэгт оруулалгүй түр хойш нь тавьсан нь дээр бололтой. Мөн өөр Нэгэн сонирхолтой дурсгал байгаа нь Кавказын өмнөд биед байгаа юм. Гүржийн Миатура хотын ойролцоох Мгхвимеви хадны хөмөгт байх сийлбэр зургуудыг 1939 онд Оросын археологч С.Замятин нээсэн боловч олны анхаарал таталгүй өнгөрсөн байдаг. Үүнийг 2022 онд Гүржийн археологчид дахин нээж нарийн тодорхойлолт, гэрэл зургуудыг нийтэлжээ. Гэхдээ эндэхийн сийлбэр зургууд нь голчлон геометр дүрсүүд бөгөөд зэрэгцээ ба хөндлөн зураасууд байдаг (Losaberidze et al. 2023).

Хадгалалт хамгаалалтын асуудал

Бага Ойгор-VI дурсгал газрын хүрмэн чулуун хадан гадарга өгөршил багатай бөгөөд маш сайн нягт газаргатай тул зураг дүрслэлүүд нь тод сайн бүтээгдсэн бөгөөд хадгалагдан үлдсэн ажээ. Он цагийн хувьд

ижилсэх Ишгэн толгой ба Арал толгойгоос хадгалалт ба үзэгдэх байдал нь хавьгүй сайн юм. Чандмань Хар үзүүр зэрэг бусад жижиг дурсгалуудтай харьцуулашгүй сайн үзэгдэж ба хадгалалттай болно.

Бага Ойгор-VI дурсгалт газрыг анх 2004 онд илрүүлэх үед авсан гэрэл зургийг 15 жилийн дараа 2019 онд авсан зурагтай харьцуулан харахад хадгалалтын ерөнхий байдал төдийлөн муудаагүй боловч хадны хаг нь мэдэгдэхүйц багассан нь ажиглагдаж байна (Зураг 4). Энэ нь хүрээлэн буй орчны өөрчлөлттэй холбоотой, ялангуяа уур амьсгалын хувьд улам хуурайшиж байгаатай холбоотой бололтой.

Цаашид уг онцгой чухал дурсгалыг хадгалан хамгаалах талаар шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Юуны урьд хамгаалалтын хайсыг барих зайлшгүй шаардлагатай. Учир нь уг дурсгал хүний хөл дээр, яг авто замын хажууд оршдог бөгөөд өнгөн хөрсний түвшинд байгаа дээшээ харсан хадан гадаргууд дээр зурагдсан учир үзэж харахын тулд зайлшгүй дээрээс нь дэвслэн явах нөхцөл үүсдэг. Ийм хэмжээний эртний бөгөөд чухал дурсгалыг дэлхийн хэмжээнд хэрхэн ач холбогдол өгч байгааг дээр өгүүлсэн товч тоймоос харж болно. Наад

зах Гобустан ба Сиега Верде, Фоз Коагийн дурсгалууд ЮНЕСКО-ийн Дэлхийн өвд орсон байдлыг баримжаа болгон дурдаж болно. Манай дурсгалын хувьд нэгэнт Дэлхийн өвийн газар нутагт байгаа нь туйлын завшаантай хэрэг боловч тусгайлан онцгой хамгаалалтад авах шаардлага байгааг дээр дурдав.

Дүгнэлт

Монгол Алтайн хадны зургийн дурсгалуудын дотор хамгийн том бөгөөд баялаг нь болох Цагаан салаа-Бага Ойгорын хадны зургийн бүсэд хамаарах Бага Ойгор-VI дурсгалт газрыг 2004 онд анх удаа илрүүлж, 2019 онд дахин илрүүлэн судалсан ажлын товч үр дүнг энэхүү өгүүлэлд танилцуулав. Зургуудын дүр дүрслэлийн асуудал, дүрслэлийн арга техникийн нарийвчилсан анализийг энэ өгүүлэлд оруулаагүй болохыг тэмдэглэе. Мөн харьцангуй он цагийн асуудлыг хөндөөгүй боловч иконографийн хувьд дээд палеолитын үед хамаарах бусад дурсгалуудтай илэрхий адил байгаа тул энэ удаа нарийвчлан авч үзсэнгүй.

Харьцангуй жижиг хэмжээтэй энэхүү дурсгалд



Зураг 4. Бага Ойгорын хадны зургийн нэгэн дүр (15-р хавтан)
А. 2004 оны зураг; В. 2019 оны зураг (гэрэл зургийг © Ц.Төрбат)

газар нь ихэвчлэн плейстоцений сүүл үеийн хадны зургууд болон цөөн тооны хүрлийн үеийн зургуудаас бүрдэнэ. Бага Ойгор-VI дурсгалт газар нь Монгол Алтайн дээд палеолитын үеийн бусад дурсгалууд болох Ишгэн толгой, Арал толгой зэрэг дурсгалуудтай ижилсэх хэмжээний ач холбогдолтой юм. Гэхдээ хадгалалтын нөхцөл байдал нь хавьгүй сайн бөгөөд зураг дүрслэлүүд нь нягт бөгөөд тод томруун болох тул өндөр сэтгэгдэл төрүүлэхүйц дурсгал болно.

Үүнтэй адилтгах дурсгалууд дэлхий дахинд харьцангуй цөөн байдаг байна. Хамгийн том бөөгнөрөл нь Иберийн хойгт байх бөгөөд Умард Европ ба Өмнөд Кавказад мөн цөөн тохиолддог ажээ.

Дэлхий дахины эртний урлагийн дурсгалын тархацад өөрийн байр суурийг Монголын палеолитын зургийн дурсгалууд эзлэх шаардлага тулгараад байна. Энэ үйл хэрэгт Бага Ойгор-VI дурсгал чухал байр суурийг эзлэх нь зайлшгүй юм. Алдарт Хойд Цэнхэрийн агуйн зосон зургийн зэрэгцээ олон тооны сийлмэл зургийн дурсгалууд судлагдаж байгаа нь Монгол Алтайн бүс нутгийг дурсгалуудын тоо, тархалтын хэмжээг харгалзан үзэж “өвөг урлагийн голомт нутаг” гэж тодорхойлж болохоор ач холбогдолтой газар болоод байна.

Abstract

BAGA OIGOR-VI: NEWLY FOUND PALEOLITHIC ROCK ART SITE IN MONGOLIAN ALTAI (Introducing paper)

**Tsagaan Turbat, Natsag Batbold
and Bikhumar Ömirbek**

In 2004, Ts. Turbat made a discovery of a significant site of engraved rock art, dating back to the Upper Paleolithic period. Situated on the south bank of the Baga Oigor River, this remarkable site lies within the protective zone of the World Heritage site of the Mongolian Altai rock art complex. The Baga Oigor-VI complex boasts an impressive array of 41 depictions featuring animals such as horses, ibex, argali, deer, cattle, and snakes from the Upper Paleolithic period, complemented by an additional 16 images originating from the Bronze Age, constituting a total of 57 images. Noteworthy is the superior preservation status of this monument, eclipsing that of comparable sites and presenting unparalleled clarity in visibility. The scarcity of open Paleolithic rock art sites across the globe that bear resemblance to this exceptional find underscores its singular nature. The geographically nearest analogous site of significance is the Gobustan monument in the South Caucasus followed by largest concentration of similar monuments in Iberian peninsula.

Beyond the renowned ochre paintings of the Khoid Tsenkher Cave, an extensive exploration of carved rock art open air monuments is underway, elevating the Mongolian Altai region to the status of a pivotal hub in the realm of ancient art. The sheer abundance and widespread distribution of these monuments contribute to its characterization as a veritable “cradle of prehistoric art”.

Keywords: Upper paleolithic, rock art open site, engraved image, carved image, Mongolia, Altai

Ном зүй

Bahn, P.G. (1995). Cave art without the caves. – In: *Antiquity*, Vol. 69(263): 231–237. DOI: 10.1017/S0003598X00064632

Bicho, N., Carvalho, A.F., González-Sainz, C., Sanchidrián, J.L., Villaverde, V., Straus, L.G. (2007). The upper paleolithic rock art of Iberia. – In: *Journal of Archaeological Method and Theory*, Vol. 14(1): 81–151. DOI: 10.1007/s10816-007-9025-5

de Balbín Behrmann, R. (2014). Siega Verde rock art sites. in: *Encyclopedia of Global Archaeology*. Ed. C.Smith. (New York:).

Huyge, D., Vandenberghe, D.A.G., De Dapper, M., Mees, F., Claes, W., Darnell, J.C. (2011). First evidence of Pleistocene rock art in North Africa: securing the age of the Qurta petroglyphs (Egypt) through OSL dating. – In: *Antiquity*, Vol. 85(330): 1184–1193.

Losaberidze, L., Zavrashvili, A., Kenkadze, V. (2023). Palaeolithic rock art from Mghvimevi, western Georgia. – In: *Archaeological Research in Asia*, Vol. 37: 100499. DOI: <https://doi.org/10.1016/j.ara.2023.100499>

Pike, A.W.G., Gilmour, M., Pettitt, P., Jacobi, R., Ripoll, S., Bahn, P., Muñoz, F. (2005). Verification of the age of the Palaeolithic cave art at Creswell Crags, UK. – In: *Journal of Archaeological Science*, Vol. 32(11): 1649–1655. DOI: 10.1016/j.jas.2005.05.002

Radchenko, S., Kiosak, D. (2022). The Upper Paleolithic rock art of Ukraine between here and nowhere. – In: *Quaternary International*, Vol. 640(August): 44–60. DOI: 10.1016/j.quaint.2022.09.008

Santos, A.T., Jesus Sanches, M., & Teixeira, C. (2015). The Upper Palaeolithic rock art of Portugal in its Iberian context. in: *Prehistoric art as prehistoric culture: Studies in honour of professor Rodrigo de Balbín-Behrmann*. Eds. P.Bueno-Ramirez & P.G.Bahn. - Oxford: Archaeopress Archaeology, 123-133.

Sigari, D. (2013). Palaeolithic rock art in Gobustan, Azerbaijan. The study case of the rock 44 of Böyük Daş, Gobustan. – In: *Iranian Archaeology*, Vol. 4: 15–22.

Sigari, D. (2022). Paleolithic Rock Art of the Italian Peninsula. - Centro Camuno di Studi Preistorici - Edizioni del Centro. - 272 pp.

Vázquez Marcos, C., Reis, M. (2019). Arroyo de las Almas (La Fregeneda, Salamanca): un nuevo sitio con arte paleolítico al aire libre. – In: *Trabajos de Prehistoria*, Vol. 76(1): 138. DOI: 10.3989/tp.2019.12230

Welker, W. (2016). First Palaeolithic Rock Art in Germany: Engravings on Hunsrück Slate. – In: *Antiquity*, Vol. 90(349): 32–47.

Zilhao, J., Aubry, T., Carvalho, A.F., Baptista, A.M., Gomes, M.V., Meireles, J. (1997). The Rock Art of the Coa Valley (Portugal) Its Archaeological Context: First Results of Current Research. – In: *Journal of European Archaeology*, Vol. 5(1): 7–49.

Бан, П. (2009). Палеолитическое наскальное искусство: история открытия и признания феномена. – In: *Уральский Исторический Вестник*, Vol. 4(53): 6–14.

Дэвлет, М.А., Дэвлет, Е.Г. (2001). Рец.: Молодин В.И., Черемисин Д.В. Древнейшие наскальные изображения плоскогорья Укок. Новосибирск. 1999. – In: *РА*, Vol. 2: 128–132.

Кубарев, В.Д. (1997). О петроглифах Калгуты. in: *Наскальное искусство Азии*. Вып. 2. - Кемерово. 88-97.

Молодин, В.И. (2009). Академик Окладников

и его концепция Центрально-Азиатского очага происхождения первобытного искусства. in: *НомоЕurasicus у врат искусства*. - СПб. 12-20.

Молодин, В.И. (2022). Древнейший пласт наскального искусства в Монголии и Южной Сибири. in: *Мир Центральной Азии-V. Сборник научных статей*. Ред. А.П.Деревянко, Б.В.Базаров. - Новосибирск, 3-7.

Молодин, В.И., Женест, Ж.-М., Зоткина, Л.В., Черемисин, Д.В., Кретэн, К. (2019). «Калгутинский» стиль в наскальном искусстве Центральной Азии. – In: *Археология, Этнография И Антропология Евразии*, Vol. 47(3): 12–26.

Молодин, В.И., Зоткина, Л.В., Кретэн, К., Плиссон, Х., Женест, Ж.-М., Черемисин, Д.В. (2021). «Калгутинский» стиль в наскальном искусстве и его своеобразие. in: *Древнее искусство в контексте культурно- исторических процессов Евразии: к 300-летию научного открытия Томской писаницы*. - Кемерово, 201-206.

Молодин, В.И., Черемисин, Д.В. (1999). Древнейшие наскальные изображения плоскогорья Укок. - Новосибирск. - 160 стр.

Молодин, В.И., Черемисин, Д.В. (2007). Петроглифы Укока. – In: *Археология, Этнография и Антропология Евразии*, Vol. 32(4): 91–101.

Окладников, А.П. (1972). Центральноазиатский очаг первобытного искусства (пещерные росписи Хойт-Цэнкер Агуй (Сэнгри-агуй, Западная Монголия).

Өмирбек, Б., Батболд, Н., Цэрэндагва, Я. (2021) Дэлхийн өв - Монгол Алтайн хадны зураг. - УБ. - 136 т.

Төрбат, Ц. (2019). Хэмцэгийн соёлын хадны зураг (2015 оны өгүүлэл). – In: *SA*, Vol. 38(1): 5–16.

Төрбат, Ц., Баяр, Д., Цэвээндорж, Д., Баттулга, Ц., Баярхүү, Н., Идэрхангай, Т., Жискара, П.Х. (2009) .Монгол Алтайн археологийн дурсгалууд-I: Баян-Өлгий аймаг. - УБ. - 424 т.

Формозов, А.А. (1983). К проблеме «очагов первобытного искусства». – In: *CA*, Vol. 3: 5–13.

